

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭХ ГЭРЭЭ

201... оны ...-р сарын ...өдөр

№

Улаанбаатар хот

Хөрөнгө итгэмжлэх гэрээ - \цаашид “гэрээ” гэх\ - г нэг талаас: “.....” ХХК-ийн захирал /РД:/;цаашид Итгэмжлэгч гэх/, нөгөө талаас: Иргэн /РД:/ цаашид Итгэмжлэгдэгч гэх/, нар Монгол Улсын Иргэний хууль, Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ

1.1 Энэхүү гэрээ нь талуудын хооронд үүссэн газрыг бусдаас худалдан авах, газар өмчлөх эрхийг иргэний нэр дээр түр шилжүүлэх, тухайн чөлөөлөгдсөн газарт барилга байгууламж барих, баригдсан барилгын газрын харилцааг холбогдох хуль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхэд үндэс суурь болно.

1.2. Гэрээний зорилго нь Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр итгэмжлэгч нь газар өмчлөх эрхийг итгэмжлэгдэгчийн нэр дээр шилжүүлэхийг зөвшөөрч, итгэмжлэгч итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авч итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулахтай холбогдох харилцааг тодорхойлход оршино.

ХОЁР. ИТГЭМЖЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Барилга барихад шаардлагтай нэгж талбарыг иргэдээс худалдан авахтай холбогдох арилжааны нөхцөлийн дагуу шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх

2.2 Тухайн нэгж талбарыг итгэмжлэгдэгчийн нэр дээр шилжүүлэх, компанийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулах үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, Илэрсэн зөрчлийг арилгуулхаар шаардлага гаргах

ГУРАВ. ИТГЭМЖЛЭГДЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Итгэмжлэгдэгч нь эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ зориулалтын дагуу чөлөөлөгдсөн талбайг зохих төлөвлөлт, төлөвлөгөөнд нийцүүлэн зохион байгуулж ажиллахтай холбогдсон эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан аливаа асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх үүрэгтэй

3.3. Итгэмжлэгдэгч нь “.....” ХХК-ийн хөрөнгөөр худалдан авсан өмлөх, эзэмших эрхийн гэрчилгээ бүхий доорхи газруудыг өөрийн нэр дээр түр шилжүүлэнэ. Үүнд:

3.3.1. Хүснэгтээр болон жагсаалтаар хавсаргах.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1. Хөрөнгө итгэмжлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцана.

4.2 Хөрөнгө итгэмжлэгдэгч нь өөрт олгодсон эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аливаа асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгээгүйгээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцана.

Үргэлжлэл бий